

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ДЭД БҮТЦИЙН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР
2021 ОН

ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Баяртунгалаг, С.Амаржаргал, З.Нямбаяр, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, доктор Б.Сайнбуян нар хамтран гүйцэтгэв.

Монгол улсын геодезийн зөвлөх инженер Ч.Цэрэнбат редакц хийж, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн багш, доктор, профессор Ч.Оюунжаргал шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: standardinform@masm.gov.mn

Цахим хуудас: www.estandart.gov.mn

www.masm.gov.mn

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

АГУУЛГА

ОРШИЛ	1
1 Хамрах хүрээ	2
2 Норматив эшлэл	2
3 Нэр томъёо, тодорхойлолт	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт	4
4 Техникийн шаардлага	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага	5
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага	7
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага	8
4.4 UML диаграмм (норматив) шаардлага	8
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага	9
4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг (мэдээллийн)	9
A Хавсралт - Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга	10
B Хавсралт - Кодын жагсаалт	68
C Хавсралт - UML диаграмм	103
D Хавсралт - Өгөгдлийн чанар	108
E Хавсралт - Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг	121

ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Дэд бүтцийн орон зайн суурь өгөгдөлд бодит биет байдлаар орших инженерийн шугам сүлжээ, байгаль орчны барилга, байгууламж, тэдгээртэй холбоотой засаг захиргаа болон нийгэм, төрийн үйлчилгээний төрлүүдийн талаарх мэдээллийг агуулна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... : 2021
Geographic information. Data specification on Utility and Government Services	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны ... дугаар сарынний өдрийн дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн сан нь инженерийн шугам сүлжээнд багтах усан хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын систем, газрын тос, байгалийн хий дамжуулах шугам сүлжээ, цахилгааны шугам сүлжээ, харилцаа холбооны шугам сүлжээ, байгаль орчны байгууламж, нийгэм, төрийн үйлчилгээ зэрэг мэдээллийг дэлгэрэнгүйгээр агуулна.

Энэхүү стандарт нь дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO 19107:2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;

ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;

ISO 19108-с: 2002/Cor 1:2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;

ISO 19111: 2007 Газар зүйн мэдээлэл – Солбицлоор илэрхийлэгдсэн орон зайн дүрслэл;

ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;

ISO 19118: 2006, Газар зүйн мэдээлэл – Кодлолт;

ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;

ISO 19125-1: 2004, Газар зүйн мэдээлэл – Энгийн биетийн хандалт - 1-р хэсэг: Нийтлэг архитектур;
ISO 19135: 2007, Газар зүйн мэдээлэл – Бүртгэлийн явц;
ISO/TS 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;
ISO/TS 19139: 2007, Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл – XML схемийн хэрэгжилт
ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;
MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо
MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл
MNS 6702: 2017 Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг
Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

Үндсэн агуулгад хамаарах ойлголт

3.1.1

орон зайн өгөгдөл

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц.

3.1.2

орон зайн суурь өгөгдөл

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл.

3.1.3

өгөгдлийн багц

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

3.1.4

стерео төрөл

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг.

3.1.5

өгөгдөл төрөл

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

3.1.6

биет төрөл

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

3.1.7

кодын жагсаалт

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутадад ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

3.1.8

домэйн

Тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлнэ. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” л байх ёстой гэсэн шалгуур домэйн болно.

3.2

Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт

3.2.1

PT_free text

Шинж чанар, агуулгыг тодорхойлж, тайлбарласан текстэн мэдээлэл. Нэг болон олон хэлээр илэрхийлэх боломжтой. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19139:2007]

3.2.2

Length

Зайг хэмждэг тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.3

Date time

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.4

Identifier

Өгөгдөл мэдээллийг хариуцагч эрх бүхий байгууллагаас олгосон орон зайн объектын танигч буюу тодорхойлогч. Энэ нь тухайн өгөгдлийг бусад программ, системүүд лавлах, холбох үед ашиглана. [Дэлгэрэнгүй мэдээллийг INSPIRE DS-D2.5]

3.2.5

Measure

Хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.6

Integer

Тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна.
[Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

3.2.7

GM_MultiSurface

Олон гадаргуу бүхий геометр биет. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.8

GM_Object

Геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд Газар зүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.9

GM_Point

Цэг бол зөвхөн нэг цэгээс бүрдэх геометр объектын өгөгдлийн үндсэн төрөл юм.
[Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

3.2.10


GM_Curve

Тасралтгүй холбогдсон, муруй хэлбэрийн шугаман дүрслэл. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19107:2003]

4 Техникийн шаардлага

4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “**өгөгдлийн багц**”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “**атрибут**”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “**кодын жагсаалт**” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Дэд бүтцийн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

4.1.4 Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «нэгдэл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

4.1.5 Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

4.1.6 Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

4.1.7 Дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **Засаг захиргаа болон төр, нийгмийн үйлчилгээ, Хүрээлэн буй орчны менежментийн байгууламж, Инженерийн шугам сүлжээ** гэсэн 3 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

4.1.8 Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн санд 27 биет төрөл, 2 нэгдэл, 6 өгөгдөл төрөл агуулна.

4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага

4.2.1 Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

4.2.2 Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

4.2.3 Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External ID/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

4.2.3.1 “Дотоод танигч /Local id/” нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байхыг шаардана.

4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/” нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/” нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэсэн байхыг шаардана.

4.2.4 Дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 –4.2.4.4 -д заасан дэд өгөгдлийн сантай холбогдоно.

4.2.4.1 “Хаяг” /Address/ нь тухайн хаягт суурилсан үйлчилгээний байршлын “Хаяг” /Address/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утганд «Хаяг» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Хаягийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.2.4.2 “Барилга” /Building/ нь тухайн барилгад суурилсан үйлчилгээний байршлын “Барилга” /Building/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утганд «Барилга» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Барилга, байгууламжийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.2.4.3 “Газар зүйн нэрийн объект” /Named place/ нь тухайн “Нэрлэсэн байршил” /Named place/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утганд «Газар зүйн нэрийн объект» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.2.4.4 “Засаг захиргааны нэгж” /Administrative unit/ нь тухайн төр, нийгмийн үйлчлэх хүрээний “Засаг захиргааны нэгж” /Administrative unit/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утганд «Засаг захиргааны нэгж» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Хил заагийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS:2021” стандартаас авч ашиглана.

4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага

4.3.1 А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

4.3.2 Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн санд 43 кодын жагсаалт агуулна.

4.3.3 А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утганд заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

4.4 UML диаграмм (норматив) шаардлага

4.4.1 Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

4.4.2 Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

4.4.3 С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага

4.5.1 Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь дэд бүтцийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.13-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

4.5.2 Дэд бүтцийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана. Үүнд:

4.5.2.1 Иж бүрдэл: биет болон тэдгээрийн атрибут, харилцан хамаарлуудын түвшин.

4.5.2.2 Утга агуулгын нийцтэй байдал: өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

4.5.2.3 Байршлын нарийвчлал: орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин.

4.5.2.4 Сэдэвчилсэн нарийвчлал: тоон атрибутуудын нарийвчлал ба тоон бус атрибутуудын бодит байдал болон биет, тэдгээрийн харилцан хамаарлын түвшин.

4.5.2.5 Хугацааны чанар: цаг хугацааны атрибут ба тэдгээрийн харилцан хамаарлын нийцтэй байдал.

4.6 Өгөгдлийн элементүүдийн тайлбар зураг (мэдээллийн)

4.6.1 Өгөгдөл бүрдүүлэхдээ агуулгын төрөл ангиллыг ялгах, танихад ашиглах жишээ болгон үзүүлсэн тайлбар зургуудыг E хавсралтаас ашиглах боломжтой.

ТӨГСӨВ

А Хавсралт
(норматив)

Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

А.1-р хүснэгт - Дэд бүтцийн орон зайн суурь өгөгдлийн багц ба стерео төрлүүд

А.1.1 Өгөгдлийн багц: Засаг захиргаа болон нийгэм, төрийн үйлчилгээний суурь өгөгдөл (Administrative and social governmental services)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Төр, нийгмийн үйлчилгээ <i>/Governmental service/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг Полигон	Төрийн захиргааны байгууллага эсвэл хувийн байгууллагуудын захиргаа, иргэний хамгаалалтын газар, сургууль, эмнэлэг гэх мэт засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээ хамаарна. Энэ хамрах хүрээг харгалзах кодын жагсаалтын үйлчилгээний төрлийн утгаар харуулна.
2	Үйлчилгээний төрөл <i>/Service type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Төрийн үйлчилгээний ангиллыг агуулсан кодын жагсаалт.
3	Үйлчлэх хүрээний төрөл <i>/Area of responsibility type/</i>	«нэгдэл» <i>/union/</i>	-	Үйлчилгээний орон зайн үүргийг тодорхойлох төрлүүдийн багц.
4	Үйлчилгээний байршлын төрөл <i>/Service location type/</i>	«нэгдэл» <i>/union/</i>	-	Үйлчилгээний байршлын лавлах төрлүүдийн багц.
5	Өмчийн хэлбэр <i>/Ownership type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Төр, нийгмийн үйлчилгээний өмчийн хэлбэрийг агуулсан кодын жагсаалт.
6	Хамрагдах хүн ам <i>/Occupancy type/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Оршин суугчдын бүлгийг тодорхойлно.
7	Нөөцийн төрөл <i>/Resource type/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Дан ганц техникийн нөөцийг тодорхойлно. Жишээ нь: Гал унтраах усан сангийн багтаамж.

8	Холбоо барих /Contact/	«өгөгдөл төрөл» /data type/	-	Үйлчилгээнд нэвтрэх ба эсвэл анхан шатны мэдээлэл авахад шаардлагатай мэдээллийг агуулдаг үйлчилгээ.
---	-------------------------------	--------------------------------	---	--

А.1.2 Өгөгдлийн багц: Хүрээлэн буй орчны менежментийн байгууламжийн суурь өгөгдөл (Environmental management facilities)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Байгууламж /Environmental management facility/	«биет төрөл» /feature type/	Цэг Полигон	Хог хаягдал, бохир усны урсац гэх мэт хүрээлэн буй орчны материалын урсгалтай холбоотой тодорхой чиг үүрэг гүйцэтгэхэд зориулагдсан, бүтээсэн, суурилуулсан байгууламж, талбай юм. Тухайлбал хог хаягдал, бохир усны урсцыг дахин боловсруулах эсвэл хаях, зайлуулах үйл ажиллагаа байж болно. Ихэвчлэн хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж (шатаах үйлдвэр, хогийн цэг эсвэл агуулах гэх мэт) нэг сайтад байж болно.
2	Байгууламжийн төрөл /Environmental management facility type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Байгаль орчны байгууламжийн ангилал.
3	Байгууламжийн одоогийн нөхцөл байдлын ангилал /Condition of facility value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Байгууламжийн одоогийн нөхцөл байдлын тухай.
4	Хүчин чадал, багтаамж /Capacity/	«өгөгдөл төрөл» /data type/	-	Үйл ажиллагааг гүйцэтгэх бодит эсвэл боломжит чадварын тоон үзүүлэлт.
5	Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэл, ангилал /Economic activity value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.
6	Зөвшөөрөл /Permission/	«өгөгдөл төрөл» /data type/	-	Албан ёсны шийдвэр (албан ёсны зөвшөөрөл)-ийг илэрхийлнэ. Байгаль орчны менежментийн байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн ашиглахыг тухайн операторын удирдаж байгаа ижил сайт дээр суурилуулах, суурилуулах хэсэг нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, тодорхой дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх албан ёсны шийдвэр (албан ёсны зөвшөөрөл) юм.

А.1.3 Өгөгдлийн багц: Инженерийн шугам сүлжээний суурь өгөгдөл (Utility service)

Д/д	Өгөгдлийн нэр	Сtereo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Шугамын холбоос /Utility link/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Сүлжээнд байрлах хоёр цэгийн хооронд дамжуулах, түгээх хангамжийн хэлбэр, хэмжээ ба холболтыг дүрсэлсэн шугаман орон зайн объект юм.
2	Шугамын холбоосны дараалал /Utility link sequence/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Шугаман холбоосон хэрэгслийн хэрэглээний захиалсан цуглуулгаас бүрдэх, орон зайн шугаман объект нь сүлжээнд ямар ч салбаргүй, тасралтгүй байх замыг илэрхийлдэг. Элемент нь тодорхой эхлэл ба төгсгөлтэй бөгөөд холболтын дарааллын байрлал бүрийг дан ганц параметрээр тодорхойлж болно.
3	Шугамын холбоосны багц /Utility link set/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Энэ нь холбоосын багцын биет төрлийг өргөтгөн кабель, дамжуулах хоолой, сувгийн ангилалд (илүү төвөгтэй) холбоосны дараалал эсвэл ангилалыг ашиглах боломж олгодог байна.
4	Шугам сүлжээний элемент /Utility network element/	«биет төрөл» /feature type/	Цэг Шулуун	Шугам сүлжээнд ашиглагддаг шугам сүлжээний элементийг илэрхийлсэн хийсвэр суурь төрөл юм. Шугам сүлжээн дэх бүх элемент нь ашиглалтын сүлжээнд ач холбогдолтой зарим функцийг хангадаг.
5	Шугамын зангилаа, гол хэсэг /Utility node/	«биет төрөл» /feature type/	Цэг	Холболтод ашигладаг орон зайн цэгэн объект.
6	Шугамын зангилаа хэсгийн агуулагч /Utility node container/	«биет төрөл» /feature type/	Цэг Полигон	Холболтод ашигладаг орон зайн цэгэн объект, мөн бусад орон зайн объектуудыг агуулж болно (нэг ашиглалтын сүлжээнд хамаарахгүй).
7	Шугам түгээлтийн төрөл /Utility delivery type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Ашиглалтын хүргэлтийн төрлүүдийн ангилал.
8	Анхааруулах, хамгаалах төрөл /Warning type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Анхааруулах, хамгаалах төрлүүдийн ангилал.
9	Босоо тэнхлэгийн дагуух байрлалын ангилал /Vertical position value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Байршлын чиглэл заасан ангилал.

10	Танхим, кабинет /Cabinet/	«биет төрөл» /feature type/	Полигон	Кабинет нь дан эсвэл олон нийтийн сүлжээнд хамаарах ашиглалтын объектыг агуулах боломжтой.
11	Суваг /Duct/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Кабель, сувгийг бэхлэх байгууламжаар хамгаалах, чиглүүлэхэд ашигладаг ашиглалтын холбоос буюу холбоосны дараалал юм.
12	Сувгийн материалын төрөл, ангилал /Duct material type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Сувгийн таг, хана, шалны материалын төрөл, ангилал.
13	Шугам хоолой /Pipe/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Хатуу бодис, шингэн, химийн бодис, хий зэргийг нэг газраас нөгөөд шилжүүлэхэд зориулсан ашиглалтын холбоос эсвэл дарааллыг хэлнэ. Хоолойг хэд хэдэн кабель (багц боодол) эсвэл бусад (жижиг) хоолойнуудыг битүүмжлэх объект болгон ашиглаж болно.
14	Шугам хоолойн материалын төрөл /Pipe material type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Шугам хоолойн материалын төрлүүдийг тодорхойлно.
15	Шугам хоолойн ачаалал, ангилал /Pipe load type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Шугам хоолойн ачаалах байдал.
16	Ил худаг /Manhole/	«биет төрөл» /feature type/	Цэг	Нэг буюу хэд хэдэн шугам сүлжээний зангилааг агуулж болох энгийн агуулагч объект.
17	Ил худгийн материалын төрөл /Manhole material type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Ил худгийн материалын төрөл, ангилал.
18	Ил худгийн төрөл, ангилал /Manhole type value/	«кодын жагсаалт» /code list/	Ангилал	Ил худаг, ил худгийн төрөл, ангилал.
19	Кабель, утас /Cable/	«биет төрөл» /feature type/	Шулуун	Цахилгаан эсвэл өгөгдлийг нэг газраас нөгөө рүү дамжуулахад ашиглагддаг ашиглалтын холбоос буюу холбоосны дараалал юм.
20	Шон /Pole/	«биет төрөл» /feature type/	Цэг	Ганц болон хэд хэдэн шугам сүлжээнд хамаарах ашиглалтын объектуудыг зөөж чаддаг энгийн тулгуур эд анги юм.

21	Шонгийн төрөл, ангилал <i>/Pole type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Шонгийн төрлүүдийг тодорхойлсон байдал.
22	Шонгийн материалын ангилал <i>/Pole material type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Шонг хийсэн материалын ангилал.
23	Цамхаг <i>/Tower/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг	Нэг болон хэд хэдэн шугам сүлжээнд хамаарах ашиглалтын объектуудыг агуулах боломжтой энгийн цамхгийн тулгуур объект.
24	Цамхгийн төрөл, ангилал <i>/Tower type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	ангилал	Цамхгийн төрөл, ангилал.
25	Цамхгийн материалын төрөл, ангилал <i>/Tower material type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цамхгийн бүтээцийн материал.
26	Цамхгийн зориулалтын төрөл <i>/Tower dedication type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цамхгийн зориулалтын төрөл.
27	Усан сан <i>/Water reservoir basin/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг Полигон	Усны нөөцийг хуримтлуулах, ашиглах зориулалтаар бий болгосон хиймэл нуур, хөв, цөөрөм.
28	Ус тусгаарлагчийн төрөл, ангилал <i>/Waterproof type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Ус тусгаарлагчийн төрөл, ангилал.
29	Усан сангийн материал, төрөл <i>/Water reservoir basin material type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Усан сангийн бүтээцийн материал..
30	Дулаалгын төрөл <i>/Insulation type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Дулаалгын төрөл.
31	Цэвэрлэх байгууламж <i>/Treatment plant/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэн Полигон	Бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламж.
32	Цэвэрлэх байгууламжийн төрөл <i>/Treatment plant type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цэвэрлэх байгууламжийн төрөл.
33	Цэвэрлэх байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг <i>/Component of treatment plant/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг Полигон	Цэвэрлэх байгууламжийн бүрэлдэхүүн хэсгүүд.

34	Цэвэрлэх байгууламжийн бүрэлдэхүүн хэсгийн төрөл <i>/Component of treatment plant type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цэвэрлэх байгууламжийн бүрэлдэхүүн хэсгийн төрөл.
35	Бохир ус цэвэрлэгээний үндсэн аргууд, ангилал <i>/Waste water treatment method major type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бохир ус цэвэрлэгээний үндсэн аргууд.
36	Бохир ус цэвэрлэгээний дэд ангилал <i>/Waste water treatment method sub type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Бохир ус цэвэрлэгээний дэд ангилал, аргууд.
37	Туслах хэрэгсэл <i>/Appurtenance/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Цэг	Шугам сүлжээний туслах хэрэгсэл.
38	Туслах хэрэгслийн тусгай төрөл <i>/Specific appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Туслах хэрэгслийн төрлүүдийг илэрхийлнэ.
39	Насос <i>/Pump/</i>	«өгөгдөл төрөл» <i>/data type/</i>	-	Насос.
40	Насосын төрөл <i>/Pump type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Насосын төрөл.
41	Усны шугам хоолой <i>/Water pipe/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Усыг нэг газраас нөгөө рүү дамжуулахад ашигладаг усны шугам хоолой.
42	Усны шугам хоолойн төрлүүдийн ангилал <i>/Water type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Усны шугам хоолойн төрлүүдийн ангилал.
43	Усны шугам хоолойн дагалдах хэрэгслийн төрөл <i>/Water appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Усны шугам хоолойн дагалдах хэрэгслийн төрөл, ангилал.
44	Цэвэр усны худаг <i>/Well/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	-	Худаг.
45	Цэвэр усны худгийн төрөл, ангилал <i>/Well type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Худгийн төрөл, ангилал.
46	Цэвэр усны худгийн материалын төрөл, ангилал <i>/Well material type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Худгийн материалын төрөл, ангилал.

47	Ус ашиглалтын төрөл, ангилал <i>/Water use dedication value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Ус ашиглалтын зориулалтын ангилал.
48	Дулааны шугам хоолой <i>/Thermal pipe/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Нэг газраас халаалт эсвэл хөргөлтийг түгээхэд ашигладаг шугам хоолой.
49	Ариутгах татуургын шугам хоолой <i>/Sewer pipe/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Ариутгах татуургын шугам хоолой (бохир ус) -г нэг газраас нөгөө рүү дамжуулахад ашигладаг бохир усны хоолой.
50	Ариутгах татуургын усны ашиглалтын хэлбэр <i>/Sewer operation type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Ариутгах татуургын усны ашиглалтын ангилал.
51	Ариутгах татуургын усны төрлүүд <i>/Sewer water type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Ариутгах татуургын усны төрлүүдийн ангилал.
52	Ариутгах татуургын шугам хоолойн туслах хэрэгслийн төрөл, ангилал <i>/Sewer appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Ариутгах татуургын шугам хоолойн туслах хэрэгслийн төрөл, ангилал.
53	Ус зайлуулах хоолой <i>/Drainage pipe/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Ус зайлуулах хоолой. /Үерийн ус зайлуулах хоолой/
54	Газрын тос, байгалийн хий, химийн шугам хоолой <i>/Oil gas chemicals pipe/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Газрын тос, байгалийн хий эсвэл химийн бодисыг нэг газраас нөгөө рүү дамжуулахад ашигладаг шугам хоолой.
55	Газрын тос, хий, химийн бүтээгдэхүүний төрөл <i>/Oil gas chemicals product type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Шугам хоолойгоор дамждаг газрын тос, байгалийн хий, химийн бүтээгдэхүүний төрөл.
56	Газрын тос, байгалийн хий, химийн туслах хэрэгслийн төрөл <i>/Oil gas chemicals appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Газрын тос, байгалийн хий, химийн бодисын хэрэглээний ангилал.
57	Цахилгааны кабель, утас <i>/Electricity cable/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Цахилгаан эрчим хүчийг нэг газраас нөгөө рүү дамжуулахад ашигладаг ашиглалтын холбоос эсвэл холбоосны дараалал юм.
58	Цахилгааны шугамын төрөл <i>/Electricity cable type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цахилгааны шугамын төрөл.

59	Цахилгааны шугам сүлжээний дагалдах хэрэгслийн ангилал <i>/Electricity appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Цахилгааны шугам сүлжээний дагалдах хэрэгслийн ангилал.
60	Харилцаа холбооны кабель <i>/Telecommunications cable/</i>	«биет төрөл» <i>/feature type/</i>	Шулуун	Мэдээллийн дохиог (PSTN, радио эсвэл компьютер) нэг байрлалаас нөгөө рүү дамжуулахад ашигладаг ашиглалтын холбоос эсвэл дараалал.
61	Харилцаа холбооны кабелийн төрөл, ангилал <i>/Telecommunications cable type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Харилцаа холбооны кабелийн төрөл, ангилал.
62	Харилцаа холбооны шугамын хэлбэр, ангилал <i>/Telecommunications line type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Харилцаа холбооны шугамын хэлбэр, ангилал.
63	Харилцаа холбооны кабелийн материалын төрөл <i>/Telecommunications cable material type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Харилцаа холбооны кабелийн материалын төрөл, ангилал.
64	Харилцаа холбооны туслах хэрэгслийн төрөл <i>/Telecommunications appurtenance type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Харилцаа холбооны туслах хэрэгслийн төрөл, ангилал.

А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн биет болон өгөгдөл төрлийн атрибутын агуулга

А.2.1 Өгөгдлийн багц – Засаг захиргаа болон нийгэм, төрийн үйлчилгээ (Administrative and social governmental services)

А.2.1.1 Биет төрлийн нэр: Нийгэм, төрийн үйлчилгээ (Governmental service)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр <i>/Geometry/</i>	ГМ_Объект <i>/GM_Object/</i>	-	-	Орон зайн объектын геометр дүрслэл.
2	Дотоод танигч <i>/Local id/</i>	Тэмдэгтийн мөр <i>/Character string/</i>	Тэмдэгтийн мөр <i>/Character string/</i>	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Шугам сүлжээний элементийг ашиглаж эхэлсэн хугацаа.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хэрэглээний шугам сүлжээний элементийн ашиглалт дууссан цаг хугацаа.
9	Үйлчлэх хүрээний төрөл /Area of responsibility/	«Area of responsibility type» «Үйлчлэх хүрээний төрөл»	-	-	Үйлчилгээний орон зайн үүрэг.
10	Холбоо барих /Point of contact/	«Contact» «Холбоо барих»	-	-	Үйлчилгээнд нэвтрэх ба эсвэл анхан шатны мэдээлэл авахад шаардлагатай мэдээллийг агуулдаг үйлчилгээ.
11	Үйлчилгээний байршлын төрөл /Service location/	«Service location type» «Үйлчилгээний байршлын төрөл»	-	-	Үйлчилгээний байршлын төрөл.
12	Хамрагдах хүн ам /Occupancy type/	«Occupancy type» «Хамрагдах хүн ам»	-	-	Оршин суугчдын тоо, бүлгийн чанарыг тодорхойлж буй төрөл.
13	Нөөцийн төрөл /Resource type/	«Resource type» «Нөөцийн төрөл»	-	-	Техникийн нөөцийн тоо, чанарыг тодорхойлно.

14	Үйлчилгээний төрөл /Service type/	Нийгэм, төрийн үйлчилгээний төрөл, ангилал /Service type value/	-	-	Нийгэм, төрийн үйлчилгээний төрөл. Service type value - харгалзах кодын жагсаалтаас авна.
15	Өмчийн хэлбэр /Ownership type/	Өмчийн хэлбэр, ангилал /Ownership type value/	-	-	Үйлчилгээний өмчийн хэлбэрийн төрөл. Ownership type value - харгалзах кодын жагсаалтаас авна.

А.2.1.2 Өгөгдөл төрлийн нэр: Үйлчлэх хүрээний төрөл (Area of responsibility type)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Засаг захиргааны нэгжээр илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ /Area of responsibility by administrative unit/	«Administrative unit» «Засаг захиргааны нэгж»	-	-	Засаг захиргааны нэгжээр илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ.
2	Нэрлэсэн байршлаар илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ /Area of responsibility by named place/	«Geographical name» «Газар зүйн нэр»	-	-	Нэрлэсэн байршлаар илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ.
3	Сүлжээгээр илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ /Area of responsibility by network/	«Network reference» «Сүлжээний лавлагаа»	-	-	Сүлжээгээр илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ.
4	Полигоноор тодорхойлогдсон үйлчлэх хүрээ /Area of responsibility by polygon/	ГМ_Олон талт гадаргуу /GM_MultiSurface/	-	-	Полигоноор тодорхойлогдсон үйлчлэх хүрээ.

А.2.1.3 Өгөгдөл төрлийн нэр: Үйлчилгээний байршлын төрөл (Service location type)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Хаягт суурилсан үйлчилгээний байршил /Service location by address/	«Address» «Хаяг»	-	-	Хаягт суурилсан үйлчилгээний байршил.
2	Барилгад суурилсан үйлчилгээний байршил /Service location by building/	«Building» «Барилга»	-	-	Барилгад суурилсан үйлчилгээний байршил.

3	Биетээр илэрхийлэгдсэн үйлчилгээний байршил /Service location by geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Биетээр илэрхийлэгдсэн үйлчилгээний байршил
4	Шугам сүлжээний зангилаагаар илэрхийлэгдсэн үйлчилгээний байршил /Service location by utility node/	Шугам сүлжээний зангилаа /Utility node/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Шугам сүлжээний зангилаагаар илэрхийлэгдэх үйлчлэх хүрээ. Жишээ нь: усны цорго эсвэл яаралтай тусламжийн дуудлагын цэг.

А.2.1.4 Өгөгдөл төрлийн нэр: Хамрагдах хүн ам (Occupancy type)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Оршин суугчдын тоо /Number of occupants/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	7	Оршин суугчдын тоо.
2	Оршин суугчдын хэв шинж /Type of occupant/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Оршин суугчдын бүлгийн чанарыг тодорхойлно.

А.2.1.5 Өгөгдөл төрлийн нэр: Нөөцийн төрөл (Resource type)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Хэмжээ /Amount/	Хэмжээс /Measure/	Бүхэл тоо /Integer/	5	Техникийн нөөцийн тоог тодорхойлно.
2	Нөөцийн төрөл /Type of technical means/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Техникийн нөөцийг тодорхойлно.

А.2.1.6 Өгөгдөл төрлийн нэр: Холбоо барих (Contact)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Хаяг /Address/	«Хаягийн дүрслэл» «AddressRepresentation»	-	-	Хаягийг текст хэлбэрээр илэрхийлнэ.

2	Холбоо барих заавар /Contact instructions/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Хувь хүн эсвэл байгууллагатай хэрхэн, хэзээ холбоо барих талаарх нэмэлт заавар.
3	Цахим шуудангийн хаяг /Electronic mail address/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Байгууллагын эсвэл хувь хүний цахим шуудангийн хаяг.
4	Ажиллах цагийн хуваарь /Hours of service/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Байгууллага эсвэл хувь хүнтэй холбоо барьж болох хугацаа.
5	Факсын дугаар /Telephone facsimile/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Байгууллага эсвэл хувь хүний факсын дугаар.
6	Телефон утасны дугаар /Telephone voice/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Байгууллага эсвэл хувь хүний утасны дугаар.
7	Цахим хуудас /Website/	Холбоос /URL/	URL	-	Байгууллага эсвэл хувь хүний цахим хуудас.

А.2.2 Өгөгдлийн багц - Хүрээлэн буй орчны менежментийн байгууламжууд (Environmental Management Facilities)

А.2.2.1 Биет төрлийн нэр: Хүрээлэн буй орчны менежментийн байгууламж (Environmental management facility)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Геометр /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Үйл ажиллагааны цогцолборын цар хүрээ эсвэл байрлалыг тодорхойлоход ашигладаг объект ба биеийн хэлбэр хэмжээ. /Оруулсан тайлбар дээр үндэслэн үйл ажиллагааны цогцолборыг эрх зүйн хувьд бүхэлд нь төлөөлөхийн тулд өөр хэмжээсийг ашиглаж болно/
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	Мэдээлэл засварласан, устгасан огноо /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	Хүчинтэй хугацаа /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектыг ашиглаж эхэлсэн хугацаа.
8	Хүчингүй болох хугацаа /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын ашиглалт дууссан цаг хугацаа.
9	Байгууламжийн төрөл /Type/	Хүрээлэн буй орчны менежментийн байгууламжийн ангилал /Environmental management facility type value/	-	-	Байгууламжийн төрлүүд. Environmental management facility type value – харгалзах кодын жагсаалтыг ашиглана.
10	Байгууламжийн үйлчилгээний хугацаа /Service hours/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Байгууламжийн үйлчилгээний хугацаа.
11	Байгууламжийн талаарх тайлбар /Facility description/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Байгаль орчны менежментийн байгууламжийн талаарх нэмэлт мэдээлэл үүнд хаяг, холбогдох талуудтай холбоо барих мэдээлэл, үнэгүй текстийн тайлбар зэрэг багтана.
12	Хүчин чадал, багтаамж /Physical capacity/	«Capacity» «Хүчин чадал, багтаамж»	-	-	Ерөнхийдөө өөрчлөгддөггүй эсвэл тодорхой хэмжээгээр өөрчлөгдөөгүй үйл ажиллагааг -

					гүйцэтгэх бодит эсвэл боломжит чадварын тоон үзүүлэлт.
13	Зөвшөөрөл /Permission/	«Permission» «Зөвшөөрөл»	-	-	Албан ёсны шийдвэр (албан ёсны зөвшөөрөл)-ийг хэлнэ. Байгаль орчны менежментийн байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн ашиглахыг тухайн операторын удирдаж байгаа ижил сайт дээр суурилуулах, суурилуулах хэсэг нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, тодорхой дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх албан ёсны шийдвэр (албан ёсны зөвшөөрөл) юм.
14	Статус /Status/	Байгууламжийн одоогийн нөхцөл байдлын ангилал /Condition of facility value/	-	-	Хүрээлэн буй орчны менежментийн байгууламжийн төлөв байдал, ашиглалтад орох эсвэл ашиглахаа болих гэх мэт. Condition of facility value - харгалзах кодын жагсаалтыг авч ашиглана.

А.2.2.2 Өгөгдөл төрлийн нэр: Хүчин чадал, багтаамж (Capacity)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Үйл ажиллагааны чиглэл /Activity/	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал /Economic activity value/	-	-	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал. *Олон улсад эдийн засгийн үйл ажиллагааны жишиг стандарт болох ISIC /Ver.4/ ангиллыг хэрэглэж байна. Хүрээлэн буй орчны барилга байгууламжийн үйл ажиллагааны чиглэлийг тус ангиллын салбар E буюу Ус хангамж, ариутгах татуургын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны ангиллаас авч ашиглана. Хэрэв энэ ангилал өөрчлөгдвөл шинэчилсэн хувилбарыг дагаж

					мөрдөнө. <i>Economic activity value</i> - кодын жагсаалтыг энэ ангиллаас авч ашиглана.
2	Орох төрөл /Input value/	Хог хаягдлын төрөл, ангилал /Waste type value/	-	-	Хог хаягдлын төрөл, ангилал. *Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаалаар батлагдсан “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” -ээс авч ашиглана. Хэрэв энэ ангилал өөрчлөгдвөл шинэчилсэн хувилбарыг дагаж мөрдөнө. Waste type value - кодын жагсаалтыг энэ ангиллаас авч ашиглана.
3	Орох утга /Input amount/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Үйл ажиллагааны оролттой холбоотой параметруудийн талаарх мэдээлэл.
4	Гарах төрөл /Output value/	Хог хаягдлын төрөл, ангилал /Waste type value/	-	-	Хог хаягдлын төрөл, ангилал. *Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаалаар батлагдсан “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” -ээс авч ашиглана. Хэрэв энэ ангилал өөрчлөгдвөл шинэчилсэн хувилбарыг дагаж мөрдөнө. Waste type value - кодын жагсаалтыг энэ ангиллаас авч ашиглана.
5	Гарах утга /Output amount/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Үйл ажиллагаанаас гарсан гаралттай холбоотой параметруудийн талаарх мэдээлэл.
6	Цаг хугацаа /Time/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Тодорхой хүчин чадлын үргэлжлэх хугацаа, жишээлбэл, хүчин чадлын хувьд 1 жилийн үргэлжлэх хугацаатай гэх мэт.
7	Тодорхойлолт /Description/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Хүчин чадлын тодорхойлолт, тайлбар.

A.2.2.3 Өгөгдөл төрлийн нэр: Зөвшөөрөл (Permission)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Байгууллагын нэр /Organization name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Байгууллагын нэр.
2	Ажилтны нэр /Employee name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Ажилтны нэр.
3	Ажилтны албан тушаал /Employee position/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	80	Ажилтны албан тушаал.
4	Зөвшөөрөл олгосон хугацаа /Decision date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Зөвшөөрөл олгосон хугацаа.
5	Зөвшөөрлийн эхлэх хугацаа /Date from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Зөвшөөрлийн эхлэх хугацаа.
6	Зөвшөөрлийн дуусах хугацаа /Date to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Зөвшөөрлийн дуусах хугацаа.
7	Тодорхойлолт /Description/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Зөвшөөрлийн тодорхойлолт, тайлбар.

А.2.3 Өгөгдлийн багц – Инженерийн шугам сүлжээ (Utility service)

А.2.3.1 Биет төрлийн нэр: Шугаман холбоос (Utility link)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	Төвийн шугамын геометр /Centreline geometry/	ГМ_Муруй /GM_Curve/	-	-	Холбоосны төвийн шугамыг төлөөлөх геометр.
2	Дотоод танигч /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	Нэрийн талбар /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	Танигчийн хувилбар /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч

					шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	Мэдээлэл бүртгэсэн огноо /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
